

Агуулга

Агуулга

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	2
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧТОДОРХОЙЛОЛТ	7
4. ТУХАЙН ЖИЛИЙН ХАЙГУУЛЫН АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ	8
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	13
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ...25	
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ.....	28
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ.....	28
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	28
11. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	33
12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	36
13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	38
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	47
15. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙНОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	48
16. ДҮГНЭЛТ	51

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

“Тахь ресурс” ХХК нь НДМХ Богд-IV блокын талбайн хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Ашигт малтмал, Газрын тосны Газар болон “Тахь ресурс” ХХК - ний хооронд 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр НДМХ хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа гүйцэтгэхээр “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” байгуулсан. 2021 оны 6 сарын 18-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас хайгуулын тусгай зөвшөөрлөө аван хайгуулын ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Төслийн зорилго: “Тахь ресурс” ХХК нь шинэ эрчим хүчний эх үүсвэр НДМХ хайгуул судалгааны ажлыг шат дараалалтай явуулж, эдийн засгийн хувьд ач холбогдолтой хэтийн төлөв бүхий метан хийн нөөцийг олж илрүүлэх зорилготой.

Хэтийн төлөв: Монгол улс нь байгалийн хийн нөөц илрэх бүрэн бололцоотой газар нутаг бөгөөд метан хийн хэтийн төлөв бүхий нөөц баялгийг олж илрүүлснээр өнөөдөр нийгэмд тулгамдаж буй олон чухал асуудлуудыг шийдвэрлэх гарц нь болно гэж үзэж байна. Үүнд:

- Эрчим хүчний аюулгүй болон хараат бус байдал
- Хямд үнэтэй шатахуун
- Хотуудын агаарын бохирдол болон үүнтэй холбоотой эрүүл мэндийн асуудлууд
- Шинэ ажлын байр болон эрүүл аюулгүй амьдрах орчин
- Эдийн засгийн тогтвортой байдал

Төслийн байршил


Бүтээгдэхүүн хуваах гэрээт Богд-IV НДМХийн талбайн зүүн зах нь Улаанбаатар хотоос баруун урагш ойролцоогоор 540 км-т орших бөгөөд Улаанбаатар-Говь-Алтай чиглэлийн төв зам дагуу байрлана. Богд IV блок нь Монгол Алтайн нүүрсний сав болон Их Богдын нүүрсний сав газруудыг дамнан оршдог.

Хүснэгт 1 Богд-IV блокын талбайд хамрах аймаг, сумд

Д/д	Хот, аймаг	Талбайн хэмжээ(га)	Сум, дүүрэг	Талбайн хэмжээ(га)
1	Баянхонгор	1705120.13	Баацагаан	666011.24
2			Баян-Овоо	40030.83
3			Баянцагаан	337808.91
4			Богд	225447.33
5			Бөмбөгөр	9739.45
6			Бууцагаан	16479.15
7			Жинст	401597.78
8			Өлзийт	8005.4

9	Говь-Алтай	1024637.96	Бигэр	214178.54
10			Дэлгэр	356249.52
11			Есөнбулаг	40817.83
12			Тайшир	30125.14
13			Халиун	42867.25
14			Чандмань	340380.3
15			Эрдэнэ	19.39
16	Өвөрхангай	176480.73	Баруунбаян	175573.62
17			Нарийнтээл	907.11

Номенклатур: L-47-114, L-47-115, L-47-95, L-47-62, L-47-87, L-47-63, L-47-51, L-47-76, L-47-51, L-47-74, L-47-88, L-47-64, L-47-50, L-47-75, L-47-100, L-47-77, L-47-88, L-47-89, L-47-90, L-47-79, L-47-67, L-47-92, L-47-120, L-47-96, L-47-78, L-47-102, L-47-103, L-47-104, L-47-105, L-47-106, L-47-107, L-47-68, L-47-93, L-47-118, L-47-94, L-47-82, L-47-91, L-47-69, L-47-119, L-47-81, L-47-80, L-47-101, L-47-108



Зураг 1 Богд IV ндмхийн хайгуулын гэрээт талбайн байршлын зураг

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын баруун хэсэгт орших НДМХ Богд-IV блокын талбай нь Говь-Алтай аймгийн 7 сум (Эрдэнэ, Дэлгэр, Бигэр, Халиун, Есөнбулаг, Тайшир, Чандмань), Өвөрхангай аймгийн 2 сум (Баруунбаян-Улаан, Нарийнтээл), Баянхонгор аймгийн 8 сум (Баацагаан, Богд, Баянцагаан, Жинст, Өлзийт, Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан), нийт 17 сумын нутаг дэвсгэрт 29046.4 км² талбайг хамарч байна.

Физик газарзүйн мужлалт¹: НДМХ Богд-IV талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалын хувьд Говийн их мужийн Хотгорын бүсшилтэй нутгийн Монгол өрнөд мужид, баруун хойд хэсгийн өндөрлөг уулстай хэсэгхэн газар нь Монгол Алтай мужид, баруунаас зүүн тийш суналттай уулс нь Говь-Алтайн мужид тус тус хамаарч байна.

Байгалийн бүс, бүслүүрээр² талбайн баруун хойд, баруун урд тал нь цөлжүү хээр, хээрийн, талбайн баруун, зүүн, хойд тал нь заримдаг цөлийн, урд нь хуурай хээрийн бүсэд хамаарна.

Чандмань: Талбайн баруун урд, урд талын бага хэсэг нь хуурай хээр, баруун, зүүн, хойд тал нь бүхэлдээ цөлжүү хээрийн бүсэд

Байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлалтаар талбайн баруун, зүүн, хойд талын хэсэг нь Алтайн ар говийн цөлөрхөг муж, урд тал нь Говийн Алтайн уулсын муж тус тус хамаарч байна.

Чандмань: талбай нь бүхэлдээ Говь Алтайн уулсын мужид хамаарна

Монгол орны усны сав газар

- Хүйсийн говь-Цэцэг нуур
- Хяргас нуур-Завхан гол
- Бөөнцагаан нуур-Байдраг

¹ **Физик газарзүйн мужлалт** гэдэг нь газар орныг байгалийн бүхий л нөхцөл буюу геологийн бүтэц, хотгор гүдгэр, уур амьсгал, ус зүй, хөрс, ургамалшил, амьтны аймгийн хам бүрдлийн талаар өөр хоорондоо тодорхой ялгаатай хэсгүүдэд хуваах явдал юм.

² Байгалийн бүс гэдэг нь Дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст уур амьсгалыг бүрдүүлэгч нарны цацраг багасаж дулааны хэмжээ буурдаг учир өргөрөг бүрд байгалийн нөхцөл янз бүр болж бүсийн шинж чанартай болохыг хэлнэ. Монгол орон өндөр уулын болон уулын тайгын бүслүүр, ойт хээр, хээр, говь, цөлийн бүс гэсэн 6-н бүс, бүслүүрт хуваагддаг.

- Орог нуур-Түй
- Таац
- Алтайн өвөр говь

Уур амьсгал: Тус нутагт өндөр уулын, хуурай хээрийн цөлөрхөг говь хээрийн уур амьсгал оршино. Чийглэгдүү хүйтэн тагийн болон дулаан говь цөлийн уур амьсгал, хагас цөл нутаг хийгээд өндөр уулын оройн хэсэгт бүрэлджээ. Өндөр уулын хуурайдуу хүйтэвтэр уур амьсгалтай.

Говь-Алтай аймгийн жилийн хамгийн хүйтэн сар нь аль ч нутгаараа нэгдүгээр сар байх бөгөөд ууландаа -17°C ... -19°C , тал бүрээсээ өндөр уулс нуруугаар хүрээлэгдсэн хөндий, говь, хоолойгоор -20°C ... -23°C хүрдэг байна. Жилийн хамгийн дулаан сар нь аль ч нутагт долдугаар сард байдаг бөгөөд агаарын дундаж температур нь ууландаа 15°C , говь, хоолойгоор 20°C ... 24°C дулаан байдаг. Өвөл зуны дундаж температурын агууриг ууландаа 25°C , говьдоо 47°C , харин үнэмлэхүй их, бага температурын хувьд ууланд 75°C , говьд 90°C хүрч температурын хэлбэлзэл өндөр уулын бүсэд харьцангуй бага, говьд их байдаг байна.

Баянхонгор аймгийн нийт нутаг нь хангай, тал хээр, говь хосолсон нутагтай тул дулаан хүйтний хэлбэлзэл ихтэй сүүлийн жилүүдийн байдлаар нийт нутгаар жилийн дундаж агаарын температур дунджаар 2.0°C дулаарсан хэдий ч улирлаар нь авч үзвэл: Тус аймгийн ихэнх нутгаар өвлийн улиралд 1.4-өөс 2.5 градус, хавар, зуны улиралд 0.2-оос 1.0 градусаар дулаарсан байна, нутгийн өмнөд хэсгээр өвлийн улиралд -0.2-оос -2.0 хүйтэрсэн хэдий ч зуны улиралд 2.0 градусаар дулаарч ажиглагдаж байна.

Гадаргын ус: Төслийн талбай орчим нь голын усны горимын хувьд хаврын шар ус, зуны хур борооны усаар үерлэдэг ба голын тэжээлийн 20% нь газар доорх ус, 25% нь цасны ус, 55% нь хур борооны ус байна. Олон жилийн дундаж урсац буюу гадаргын усны урсцын модуль уулс хоорондох хөндийн шал, нам хотос газарт $0.1-1$ л/с*км², газрын гадаргуугийн харьцангуй өндөршлийн зөрүү ихтэй газарт $1-2$ л/с*км², гол мөрний нийлбэр урсац талбайн хойд, зүүн, баруун талд байх Бигэр нуурын орчмын уулс хоорондох хөндийн шал, нам хотос газруудад 20 л/с*км², Хулангийн шанд талбай орчимд $30-50$ л/с*км², газрын өндөршлийн зөрүү ихтэй газарт буюу Чандмань талбай орчимд $50-100$ л/с*км², Дэлгэр талбай орчимд $50-300$ л/с*км², хур борооны хамгийн их урсац судалгааны талбай хойд, зүүн талаар 10 мм-ээс бага, талбайн баруун хойд, урд талд $10-30$ мм, голын сүлжээний нягтшил $0.01-0.05$ км/км², шар усны үерийн хамгийн их урсац уулс хоорондох хөндийн шал, нам хотос газруудад 4 мм, газрын өндөршлийн зөрүү ихтэй газарт $20-40$ мм, усны гадаргаас уурших ууршилт $5-9$ дугаар сард $500-900$ мм байна.

Газрын доорх ус: Төслийн талбайн газрын доорх усны нөхөн сэргээгдэх нөөц нь Байдраг, Түй, Таац гол болон зарим уул нуруудын хормой бэл газарт хуримтлагддаг байна. Богд-4 талбайд нөхөн сэргээгдэх нийт нөөц нь 397.1 м³/жил, ашиглалтын баримжаат нөөц 248.93 м³/жил байна.

Хөрсөн бүрхэвч: Монгол орны хөрс - газарзүйн мужлалтын хувьд төслийн талбай нь Говийн их мужийн Хотгорын бүсшилтэй нутгийн Монгол өрнөд мужид, баруун хойд хэсгийн өндөрлөг уулстай хэсэгхэн газар нь Монгол Алтай мужид, баруунаас зүүн тийш суналттай уулс нь Говь-Алтайн мужид хамаарна.

Богд-IV блокын талбайн газрын гадарга нь ерөнхийдөө бэсрэг уулс, ухаа гүвээ толгод, өргөн, нарийн хөндий, хужир марз бүхий хотгор хонхороос бүрдэнэ. Эндхийн уулс нурууд нь баруунаас зүүн тийшлэх тутам аажмаар намсдаг онцлогтой.

Хөрс нь элсэрхэг бүтэцтэй бөгөөд ус чийг ховордуу, харин агаарын температур овоо их нөхцөлд бүрэлдэн тогтжээ. Хүрэн хөрс зонхилж ухаа гүвээ болон уултай нутгаар дэлгэр тархана. Говийн нөлөөний улмаар цайвар хүрэн хөрс, говийн бор хөрстэй хослон тархсанаас гадна олон хотгороор хужирлаг хөрс, хужир марц түгээмэл байна. Үүний зэрэгцээгээр хөрсгүй элсэн тарамцаг байдаг.

Ургамлан нөмрөг: Монгол орны ургамал газарзүйн мужлалтаар төслийн талбай нь Евразийн хээрийн их муж буюу Төв азийн дэд их мужийн, Монголын хээрийн болон говийн умард цөлөрхөг хээрийн буюу Монгол Алтайн уулын дэд бага муж, Алтайн өвөр говийн говийн дэд бага мужид тус тус багтана. Алтайн өврөөр говийн ургамалтай. Ууландаа уулын хээр, хойд хэсгээрээ хээрийн ургамал тархжээ.

Сүүлийн 5-н жилийн мэдээнээс үзэхэд судалгааны талбайн ургамалжилт буурах хандлагатай байна. Энэ нь сүүлийн жилүүдэд орох хур тунадасны өөрчлөлт болон дулааралт эрчимтэй явагдаж байгаатай холбоотой.

Амьтны аймаг: Төслийн талбай нь амьтны аймгийн газарзүйн мужлалтаар Монгол-Түвдийн их муж Хээрийн ба ойт хээрийн дэд мужийн Монгол дагуурын тойрог, Говийн дэд мужийн Хойд говь, Говь-Алтайн тойрогт хамаарагдаж байна. /А.Г.Банниковын 1954/. М талбай нь Өвөрхангай аймгийн Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Баянхонгор аймгийн Богд, Жинст, Баацагаан, Баянцагаан Говь-Алтай аймгийн Чандмань, Бигэр, Дэлгэр сумын нутаг дэвсгэрийг хамрах бөгөөд Энэ бүс нутагт янгир, аргаль хонь, бор туулай, үлийн цагаан оготно, үнэг, хярс, цагаан үен, мануул, шилүүс зэрэг хөхтөн амьтад, шилийн сар, хээрийн бүргэд, нөмрөг тас, адууч чогчиго, шоорон эвэрт болжмор, монгол болжмор зэрэг шувууд,

цоохор хонин гүрвэл, могой гүрвэл, говийн гүрвэл зэрэг мөлхөгч амьтад түгээмэл тохиолдоно.

Богд-IV талбайд 47 зүйлийн хөхтөн амьтан, 159 зүйлийн шувуу, 8 зүйлийн мөлхөгч, хоёр нутагтан, 300 гаруй зүйлийн сээр нуруугүйтэн амьтад бүртгэгджээ.

Нийгэм, эдийн засгийн байдал: Говь-Алтай аймгийн Дэлгэр, Чандмань, Баянхонгор аймгийн Баацагаан, Баянцагаан сумдын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг статистикийн мэдээлэл болон асуумж судалгааны үр дүнд тулгуурлан хийгдсэн. Асуумж судалгааг блокын талбайд нутагладаг малчдын дунд хийсэн ба нутгийн ард иргэдийн төслийн талаарх бодол санал, хүлээлт, тэдний хэрэгцээ шаардлага болон амьдрал ахуйд гарч буй цаашид гарч болохуйц нөлөөллийг мэдэх зорилгоор явуулсан. Төслийн явцад иргэдийн санал, төслийн үр дүнд үндэслээд төслийн улмаас сумын ард иргэдийн амьжиргаа нийгэм эдийн засагт гарч болохуйц эерэг сөрөг өөрчлөлт, нөлөөллийг тодорхойлж, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тал дээр араг хэмжээ авч ажилласан.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хайгуул хийгдэх талбайн ургамлын бүрхэвч сийрэг, говь хээрийн эмзэг хөрстэй учир хүнд даацын болон бага оврын машин, техник тоног төхөөрөмжийн хөдөлгөөнөөс газрын гадарга, хөрс элэгдэлд орж мөн тухайн орчинд тоосжилт үүсгэж агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.

Өрөмдлөгийн үйл ажиллагааны үед автомашин, өрмийн тоног төхөөрөмж зэргийг тээвэрлэх, байршуулахад олон салаа зам үүсэх магадлалтай, үүний улмаас газрын гадарга талхлагдан хөрс, ургамлын бүрхэвчид өөрчлөлт оруулна.

Өрөмдлөгийн үед хөрсөнд амьдардаг амьтад, газар, бутан дээр үүрээ засдаг шувуудын үүр эвдрэх, өндөг, ангаахай, дэгдээхэй, шавж өртөх магадлалтай.

Хайгуулын үйл ажиллагааны улмаас мал, амьтны тархац, шилжилт хөдөлгөөн, идэш тэжээлийн байдалд сөрөг нөлөөлөл учирч магадгүй.

Шатахуун, тослох материал, хог хаягдлаас хөрс бохирдсоноос амьтан хордох сөрөг нөлөөлөл учирч болзошгүй.

Шөнө үйл ажиллагаа явуулбал дуу чимээ, гэрлээс шөнийн амьдралтай амьтад дайжих, идэш тэжээл нь багасах зэрэг сөрөг нөлөөтэй.

Явуулын хүн олноор нэмэгдсэнээс хууль бус ан агнуур ихсэх магадлалтай.

4. ТУХАЙН ЖИЛИЙН ХАЙГУУЛЫН АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

4.1. ХАЙГУУЛЫН АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол улсын баруун хэсэгт орших НДМХ-ийн БХГ-т Богд-IV блокын талбай нь Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай аймгийн 17-н сумдын 29,062.4 км² газар нутгийг хамрах ба Дэлгэр, Чандмань, Хулангийн шанд гэсэн нарийвчилсан хайгуулын 3 талбайг өмнөх хайгуул судалгааны үр дүнд үндэслэн ялгасан байна.

2023 онд цэглэн сорьцлолтын ажлыг “Тахь Ресурс” ХХК-н геологичид хийн гүйцэтгэж, өрөмдлөгийн болон геофизикийн чичирхийллийн судалгааны ажлыг гэрээлэгч компаниар гүйцэтгүүлсэн.

4.2. ХАЙГУУЛЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН АРГА, АРГАЧЛАЛ

2023 оны хайгуулын ажлыг бэлтгэл ажил, өрөмдлөгийн ажил-үртсэн болон керн хосолсон өрөмдлөг, геофизикийн судалгаа, суурин боловсруулалт гэсэн үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

4.2.1. БЭЛТГЭЛ АЖИЛ

Хээрийн судалгааны өмнөх шатанд дараах бэлтгэлүүдийг хангаж ажилласан. Үүнд:

- Төслийн талбайд өмнө нь гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлуудын тайлан материалуудтай танилцан одоо мөрдөгдөж байгаа Ашигт Малтмалын тухай хуулийн хүчин төгөлдөр заалтуудыг баримталж, “Газрын хэвлийн тухай” “Усны тухай” хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн заалтуудыг чанд мөрдөн үйл ажиллагаагаа явууллаа. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг холбогдох мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн. Тухайн жилд хэрэгжүүлэх БОМТөлөвлөгөөг БОАЖЯамаар батлуулж холбогдох Төрийн байгууллагуудад тус бүр нэг нэг хувийг хүргүүлсэн.
- Богд-IV хайгуулын талбайд геофизикийн судалгааны ажлыг гүйцэтгүүлэхээр тендер зарлан “Геосигнал ” ХХК-г шалгаруулж гэрээ байгуулсан.
- Богд-IV хайгуулын талбайд цооногийн өрөмдлөгийн ажлыг гүйцэтгүүлэхээр тендер зарлан “Топ Даймонд Дрилинг ” ХХК-г шалгаруулж гэрээ байгуулсан.
- Өмнөх судалгааны бүх мэдээ материалтай нарийвчлан танилцан дүн шинжилгээ хийж, хээрийн ажлын үед хэрэглэгдэх байр зүйн зураг, ашигт малтмал, геологийн зургуудыг хээрийн ажилд хэрэглэгдэх хэмжээгээр хэвлүүлж бэлтгэсэн. Хээрийн нөхцөлд ажиллах боловсон хүчний асуудлыг шийдсэн.

- Хээрийн ажилд хэрэглэгдэх эд аж ахуйн болон багаж хэрэгслийг компанийн агуулахаас авч зарим байхгүй хэрэгслүүдийг худалдаж авсан.
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөө зохион БОАЖЯамаар батлуулж холбогдох Төрийн байгуулагуудад хүргүүлэн талбайн ерөнхий байдалтай газар дээр нь урьдчилан танилцсан.

4.2.2. ӨРӨМДӨЛГИЙН АЖИЛ ҮРТСЭН БОЛОН КЕРН ХОСОЛСОН ӨРӨМДЛӨГ

Энэхүү цооногийг өрөмдөх гол зорилго нь нүүрсний давхаргаас өндөр чанартай чөмгөн дээж авах, сонгосон интервалын дээжийг ашиглан тухайн ордын хийн агууламж, шинж чанарыг тодорхойлох юм.

Нүүрсний давхаргын метан хийн эрлийн болон десорпц тест хийх цооногийг өрөмдөхдөө Австрали улсын СВМ өрөмдлөгийн стандартыг баримталж өрөмдөнө. Тухайн өрөмдлөгийн онцлог нь:

1. Цооногийн тогтвортой байдлыг дээд зэргээр хангаж явах
2. Эрдэсийн онцлогоос шалтгаалан чөмгөн дээжинд өрөмдлөгийн явцын нөлөөллийг боломжит доод түвшинд барих
3. Нүүрсний давхаргаас чөмгөн дээжний гарцыг хамгийн дээд боломжит дээд түвшинд байлгах

Өрөмдлөгийн ажлын баримтжуулалтыг Австрали улсын Geogas компаний аргачлал зааварчилгаа болон Монгол улсад мөрдөгдөж буй хайгуулын арга аргачлал, заавар журмын дагуу бүрдүүлж анхдагч баримт материал, фото зураг зэргээр баталгаажуулан тусгай сан үүсгэн хадгална.

4.2.3. ХОЕР ХЭМЖЭЭСТ ЧИЧИРХИЙЛЛИЙН /СЕЙСМИЙН/ СУДАЛГАА

“Геосигналс” ХХК нь “Тахь Ресурс” ХХК- тай геофизикийн чичирхийллийн судалгааны ажил гүйцэтгэх гэрээний дагуу Говь-Алтай аймгийн Чандмань сумын Баянбуурал 3-р багийн нутагт 2023 хээрийн хэмжилтийн ажлыг 2023 оны 10сарын 16-с 2023 оны 10 сарын 27-ний хооронд Чандмань сумаас 5 туслах ажилчин нэмж авч, мөн “Тахь Ресурс”ХХК-ний 2 ажилчин нийт 19 хүн инженер техникийн болон бусад нийт 19 хүний бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгэсэн. Хээрийн ажлын гүйцэтгэлийн явцад Ашигт малтмал, газрын тосны газрын холбогдох мэргэжилтэнд өдрийн мэдээг явуулж байсан ба талбайн боловсруулалтын үр дүнг шугам тус бүрээр захиалагчид

ТОГТМОЛ ХҮРГҮҮЛЖ АЖИЛЛАСАН.

2D сейсмийн судалгааны ажлын бичлэгийн аргачлал болон параметрууд

Чичирхийллийн судалгааны ажлын аргачлал:

Хэмжилт хийх геометр:

Геометрийн хүрээ : 0-2.5-595 м

Идэвхтэй сувгийн дугаар : 120

Өдөөлтийн цэгийн хоорондын зай: 20 м


Хүлээн авах цэгийн хоорондын зай: 6 м

Давталт: 15

Цохилтын цэг геофон 2-ийн хоорондын зай хамгийн багадаа : 2.5 м

Цохилтын цэг геофон 2-ийн хоорондын зай хамгийн ихдээ: 595 м

Бичлэгийн схем: Roll on and off, unsplit active spread



Зураг 2 Бичлэгийн схем.

S_i – Өдөөлтийн цэг R_i – Хүлээн авагчийн цэг

Тайлбар: Шугам бүрийн төгсгөл дээр илүү 120 суваг дэлгэж бүтэн давталт авна. Бүх шугамын хувьд нийт хэмжилт хийж буй хэсэг нь өдөөлтийн цэгээр эхэлж өдөөлтийн цэгээр дуусах ба шугамын төгсгөл хэсэгт өдөөлтийн цэгээс цааш 595 м долгион хүлээн авах цэгүүд илүү дэлгэгдэх бөгөөд энэ нь шугамын төгсгөл хэсэгт мэдээллийг бүрэн авах давуу талтай юм.

Тоног төхөөрөмж:

Тоног төхөөрөмжийн загвар : GEIST 176 сувагтай

Хүч нэмэгдүүлэгч : өндөр 40 дицбел

Нам давтамжийн шүүлтүүр : байхгүй

Өндөр давтамжийн шүүлтүүр : байхгүй

Долгион түүвэрлэж авах зай : 0.25мсек

Бичлэгийн урт : 2048 мсек

Бичлэгийн формат : SEG-Y

Бичлэгийн хэрэгсэл: Эх хувийг DVD дээр хуулна .

Долгион өдөөгч:

Долгион өдөөгчийн төрөл: Механикжуулсан лантуу

Долгион өдөөгчийн нэр: Bobcat S250 механикжуулсан лантуу

Тухайн үеийн жин: 1925 lbs.

Лантууны жин: 1140 lbs.

Минут тутамын цохилтын хэмжээ: 20

Нэг цэг дээрх цохилтын тоо: 3-5 удаа

Тайлбар: Тухайн цэг дээр цохихдоо цохилтын хүчний чиглэлийг доош чиглүүлэх мөн бас цохилтын хүчийг саармагжуулахгүйн үүднээс доор нь 50см х 50 см х 4 см хэмжээтэй төмөр дөш тавьж өгнө. Ингэснээр мөн Drop hummer -ийн цохилтын хошуу газарт шигдэхгүй. Нэг цэг дээр хамгийн багадаа хэдэн удаа цохихийг тухайн газар тест хийж тогтооно.

Геофон:

Геофоны загвар: DX- 60 Hz or DX-40Hz

Геофоны групп: Each geophone with 12cm spike

Тайлбар: Жижиг сейсмд ихэвчлэн 1 мэдрэгчтэй 40Гц эсвэл 60Гц геофон ашигладаг ба гол нь хадаас нь урт байх ёстой. Дундажаар 12 см байдаг ба ингэснээр газарт сайн сууж барьцалдаж өгдөг. Манай компани нь тухайн газарт туршилтийн хэмжилт хийж байж геофоны сонголтоо хийдэг.

Геодезийн хэмжилт

GPS-ийн хяналтын цэгүүд нь ажлын бүсийн тухайн газрыг тогтмол эмх цэгцтэй ангилж долгион өдөөх болон хүлээн авагчийн цэгийг өндөржилт болон байрлалын нарийвчлалыг хангана. GPS-н хяналтын цэгийн судалгааг ажлын бүсийг хамруулж Статик хэмжилт ашиглан хийнэ. GPS-ийн хяналтын цэгийг ашиглан долгион өдөөх болон хүлээн авах цэгүүдийг RTK хэмжилтээр хэмжиж суурьлуулна.

Хэмжилтийн баг нь хэмжилтийн бүх үйл явцад нарийвчилсан хяналтын цэгтэй харьцангуйгаар хэмжилтийг хийж нарийвчлалын стандартын дагуу тодорхой чанартай хийж гүйцэтгэнэ.

4.2.4. СУУРИН БОЛОВСРУУЛАЛТ

Талбайн боловсруулалтыг шалгасан цэгийн үр дүнгээс хамаарч тухайн талбайд тохируулан тоног төхөөрөмжийн жагсаалт хэсэгт дурдсан тоног төхөөрөмж болон програм хангамж ашиглан доорх дарааллыг үндэслэж хээрийн боловсруулалтыг шугам болгоны ард хийж гүйцэтгэсэн.

Олон төрлийн долгионоос гүний мэдээллийг агуулж байгаа долгионыг зөв таньж, мөн үүн дээр нэмэгдээд өгөгдлийг боловсруулах бүх явцад газрын гүний ерөнхий бүтцийг сайн гаргаж өгсөн. Тохирсон боловсруулалтын дезайнийг доор үзүүлэв. "Бичил Сейсм" ХХК-ийн чичирхийллийн хайгуулын өгөгдөл боловсруулалтыг гүйцэтгэхдээ “RadExPro”, “GreenMount”, “SeiSee”, “Seismodule Controller” ба “ProMax” гэх мэт программ хангамжуудыг ашигласан.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмээ	Зардал /мян.төг/	Биелэлт	Баримталж ажилласан эрх зүйн баримт бичиг, стандарт
	1	2	3	8	9
1.	Агаарын чанар	Агаар мандлын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжиж стандарт хэмжээнд байгаа эсэхэд мониторинг хийх	Мониторингийн судалгааны зардалд багтсан	Хайгуулын талбай тус бүр дээр хийгдсэн	MNS 00172-3-16:1988 MNS 4585:2016
2.	Гадаргын багазрын доорхи усны нөөц	Нарийвчилсан хайгуул хийх талбайд байх малын хөлөөр бохирдолд өртөж, ундарга нь дарагдаж болзошгүй булгийн эхийг хамгаалах, эрүүл ахуйн дэглэмийн бүсийг тогтоох	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Хээрийн судалгааны ажил эхлэхийнөмнө сургалт зохион байгуулж, ажилчдад заавар, зөвлөмж өгч ажилласан	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
3.	Хөрсөн бүрхэвч	Шатах тослох материал хөрсөнд алдагдахаас сэргийлэх үүднээс судалгааны багт сургалт, сурталчилгаа хийсэн	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Шатах тослох материал хөрсөнд алдагдахаас сэргийлэх үүднээс судалгааны ажил эхлэхийн өмнө сургалт зохион байгуулсан. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан.	MNS5850:2019, MNS6148:2010
		Зөөврийн био жорлон ашиглах	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Хээрийн судалгааны үед зөөврийн био жорлон ашигласан	MNS5850:2019 Хөрсний чанар.Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ
		Хатуу, шингэн хог хаягдлыг төвлөрсөн хог хаягдлын цэг рүү зохих журмын дагуу ачиж зайлуулах	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Хээрийн судалгааны үед түр кэмпэд хог хаягдлыг ангилан ялгаж, ажил дууссаны дараа сумын төвлөрсөн хогийн цэгт хаясан	Хог хаягдлын тухай хууль, 2012 он MNS 5344:2003
		Олон салаа зам гаргаж бэлчээрийг доройтуулахаас сэргийлэх талаар ажилчдын дунд сургалт явуулах, үйл ажиллагаанд хяналт тавих	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Хээрийн судалгааны ажил эхлэхээс өмнө ажилчдад сургалт зохион байгуулж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан. Нэг замын бодлого баримтласан.	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, MNS 5917:2008

		Элс, даавуунд шингээх, spill kit ашиглах /бэлэн байдалд байлгах/ зэргээр хөрсийг саармагжуулж, цэвэрлэх	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Иж бүрдлийг хайгуулын түр кэмпэд бэлэн байлгаж байсан	MNS 5850:2019
4.	Ургамлан нөмрөг	Талхлагдсан газарт биологийн нөхөн сэргээлт хийх	-	Өрөмдлөгийн ажил 2023 оны 08-сарын 13-нд дууссан учир байгалийн бүс бүслүүрээс хамаараад ургамал ургах нөхцөлгүй байсан тул 2024 оны 2-р улиралд тариалахаар аймаг, сум орон нутгаас зөвшөөрөл авсан.	
		Ургамлын бүрхэц, бүлгэмдэл, зүйл, бэлчээрийн ургамлын гарц, биомассыг тодорхойлох	ОХШХ-ийн зардалд тусгагдсан	Хоёр хэмжээст чичирхийллийн судалгааны шугамын дагуу болон нарийвчилсан хайгуулын талбай тус бүр дээр ОХШ-ний ажлын хүрээнд хийгдсэн.	Ургамлын судалгааны арга зүйн дагуу (мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх)
5.	Амьтны аймаг	Хайгуул, өрөмдлөгийн ажлын үед анхаарал болгоомжтой зорчих талаар жолооч нарт сургалт явуулах	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Хээрийн судалгааны ажил эхлэхийн өмнө сургалт зохион байгуулж, ажилчдад заавар, зөвлөмж өгч ажилласан	Амьтны тухай хууль
		МУ-ын улаан ном, бүс нутгийн болон ОУ-ын улаан данс (IUCN), бусад хууль тогтоомж, гэрээ конвенциор хамгаалагдсан ховор, нэн ховор зэрлэг амьтдын талаар сургалт зохион байгуулах	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Хээрийн судалгааны ажил эхлэхийн өмнө Нийт ажилчдын ХАБЭА боло БО-ны сургалт зохион байгуулж, ажилчдад заавар, зөвлөмж өгч ажилласан	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Амьтны тухай хууль
	Нийт	-	-	-	-

2023 оны Богд-IV блокийн хайгуулын талбайд өрөмдлөг хийхэд сум орон нутгийн Засаг даргын захирамжаар түр кэмп байрлах газрын зөвшөөрлийг авсан бөгөөд гэрээний үүргийн дагуу хайгуулын ажил явагдах үед гэрээг байгуулж гэрээний дагуу зохих төлбөрийг төлж ажилласан /Гэрээг хавсаргав/. Мөн өрөмдлөгийн ажил явагдах үед хөрсний блохирдол үүсэхээс сэргийлж дараах арга хэмжээнүүдийг авч ажилласан. Үүнд:

- Ажилчдыг хог хаягдал хаях, ил задгүй бие засахгүй байх тал дээр анхааран ажиллаж хээрийн ангид био нойлыг ашиглан, ажилчдын ариун цэврийн газрын ариутгал цэвэрлэгээний ажлыг тогтмол хийсэн.
- Хогийн савыг байршуулж, ахуйн хог хаягдлыг ялган ангилж, өрмийн ажил дуусахад Хог хаягдлын гэрээний дагуу хогийг зөвшөөрөгдсөн хогийн цэгрүү нийлүүлж ажилласан.
- Машин техникийн шатахууны тос, тосологооны шингэн асгаралт шүүрэлтээс хамгаалж өрөмдлөгийн шингэжн хаягдлын сан, машины зогсоол, генератор доор пластикийн уутыг дэвсэж хөрс бохирдохоос хамгаалсан.



Зураг 3 Өрөмдлөгийн машин доор пластик уут дэвсэж хөрсөнд тос, тосолгооны материал нэвчихээс сэргийлсэн.



Зураг 4 Өрөмдлөгийн ус хадгалах шингэний зумп



Зураг 5 Генераторын доод хэсэгт хөрс хамгаалах пластик уут дэвссэн байдал



Зураг 6 Зөөврийн боловсон нойл

1тн хэмжээтэй хуванцар савыг байршуулж дээр нь зөөврийн контейнарыг байршуулан зөөврийн био нойлыг хийсэн бөгөөд хуванцар савыг байршуулсанаар бохир шууд хөрсөнд нэвчихгүй байгаль орчинд сөрөг нөлөөгүй байхаар шийдсэн.


6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 3 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Биелэлт	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6		
1.	Техникийн нөхөн сэргээлт	Цооногуудын ханыг цементийн зуурмагаар битүүмжлэх	Өрөмдлөгийн үйл ажиллагааны зардалд багтсан			Түр кэмп байрласан газарт бага хэмжээний Био 00-ийн сефтик танк суулгах зориулалтаар ухсан нүх болон өрөмдлөгийн шингэн хуримтлуулах зумпийг нөхөн сэргээсэн.	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917 : 2008	
2.		Цооногуудын амсарыг таглах, аюулгүй болгох	Өрөмдлөгийн үйл ажиллагааны зардалд багтсан					
3.	Биологийн нөхөн сэргээлт	Өмөрмдлөг хийх талбай болон өрмийн түр кэмп байрших талбайд олон наст ургамлын үр цацах	га	0.8	-	Сүүлийн өрөмдлөгийн үйл ажиллагаа 2023 оны 08 сарын 13-нд дууссан бөгөөд олон наст ургамал тариалахад цаг агаарын нөхцөл байдал хүнд ургахад үр дүнг муу байна гэж үзэн биологийн нөхөн сэргээлтийг 2024 оны хавар хийхээр аймаг, сум орон нутгаас зөвшөөрөл авсан.		
4.		Өрөмдлөг хийсэн талбайд талбайд мод, суулгац тарих / хайлаас, улиас, шар хуайс г.м бусад /	га	1000	5000	500000		Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн хүрээнд Чандмань, Дэлгэр суманд нийт 1000ш улиас, хайлаас, бургас зэрэг төрлийн модыг тариалсан.

НДМХ-ийн Онги-V талбайд хийгдсэн Говь-Алтай аймгийн Чандмань болон Дэлгэр суманд орших TR-B4-01, TR-B4-02-DEL, TR-B4-02-DEL, TR- B4-03-DEL, TR-B4-04-DEL дугаар бүхий цооногуудын техникийн нөхөн сэргээлтийн хийж Чандмань сумын засаг даргаар томилуулсан ажлын хэсэг, Дэлгэр сумын засаг даргаар томилуулсан ажлын хэсэгт тус тус техникийн нөхөн сэргээлтийг газар дээр шалгаж хүлээн авсан. 2024 онд хийх биологийн нөхөн сэргээлтийг хийхийн мөн сануулж байсан. Бид мөн хариуцлагатайгаар хийнэ гэдгийг мэдэгдсэн.

2023 оны 06-р сарын 27-нд Чандмань сумын TR-B4-01 цооногт (648.6м) өрөмдлөги болон каротажийн ажил дууссаны дараа “Топ даймонд дриллинг” ХХК-ийн өрмийн баг цооногт 2 ширхэг бөглөөс 435м болон 20м гүнд суурилуулж, 435-460м 780 литр (0.76 шоо метр) цемент цутгасан. Гадаргуу хэсгийг 250 литр (0.21 шоо метр) цементээр дүүргэсэн 20м-ийн гүнд мөн адил бөглөөс суурилуулсан. Гадарга хэсэгт бид цементлэх ажил эхлэхээс өмнө 12м НWT штанг суурилуулж дуусгасан. Дээрх арга аргачлалаар цооног тус бүр дээр бөглөөсийг хийж цемент цутгасаны дараагаар бэхэлгээний янданг суурилуулснаг. Бэхэлгээний янданг гүнээс хамааруулан хэдэн метрт суулгахаа тооцоолдог. Цооног тус бүр дээр нүүрсний давхаргын үеүүдэд ус нэвчих, хий ялгарах, цөмрөх зэргээс сэргийлж цооногуудын ханыг бөглөж, бэхэлгээний яндан суурилуулан битүүмжлэх нь байгаль орчин ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй үзүүлдэггүй.



Зураг 7 Цооногийн ханыг бөглөх, битүүмжилж буй процесс

6.1 Чандмань сумын нутагт хийгдсэн TR-B4-01 өрмийн 1цооногийн Техникийн нөхөн сэргээлт



Зураг 8 Өрмийн цооногийн шинэгний хаягдлын техникийн нөхөн сэргээлт хийгдэж буй байдал



Зураг 9 Техникийн нөхөн сэргээлт дууссан байдал



Зураг 10 Техникийн нөхөн сэргээлт дууссан байдал



Зураг 11 Цооногийн хаягжуулалт

TR-B4-01 дугаартай цооногийн техникийн нөхөн сэргээлтийг сумын Засаг даргын захирамжаар томилогдсон нөхөн сэргээлтийг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд хүлээлгэн өгсөн. / Нөхөн сэргээлт хүлээлгэн өгсөн баримт бичгийг хавсаргав/



Зураг 12 TR-B4-01 цооногийн техникийн нөхөн сэргээлттэй танилцаж буй байдал



Зураг 13 Сумын нөхөн сэргээлтийн комиссын бүрэлдэхүүнц ооногийн хаягжуулалттай танилцаж буй байдал

6.2 Дэлгэр сумын TR-B4-02-Del, TR-B4-03-Del, TR-B4-04-Del цооногуудын техникийн нөхөн сэргээлт



Зураг 14 Цооногуудын техникийн нөхөн сэргээлт хийгдэж буй байдал



Зураг 15 Дэлгэр сумын цооногуудын ТНС хийж дууссаны дараах байдал

TR-B4-02-Del-TR-B4-04-Del дугаартай цооногийн техникийн нөхөн сэргээлтийг сумын Засаг даргын захирамжаар томилогдсон нөхөн сэргээлтийг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд хүлээлгэн өгсөн. / Нөхөн сэргээлт хүлээлгэн өгсөн баримт бичгийг хавсаргав/



Зураг 16 Цооногийн хаягжуулалт, битүүмжлэлтэй танилцаж буй байдал



Зураг 17 Нөхөн сэргээлтийн комиссын бүрэлдэхүүнд техникийн нөхөн сэргээлтийг хүлээлгэн өгч буй байдал

Өрөмдлөг дууссаны дараагаар цооногуудыг MNS 6200:2010 стандартын дагуу хааж бимтүүмжлэсэнээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох АМГТГ-т хүлээлгэн өгдөг.

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Өрмөдлөгийн талбайн дүйцүүлэн нөхөн сэргээлтийн хүрээнд Чандмань болон Дэлгэр сумын ногоон байгууламжын талбайд улиас, хайлаас, бургас зэрэг модыг Мод тарих үндэсний өдөр болох 10-р сарын хоёр дахь долоо хоногийн Бямба гаригт тариалсан.

Чандмань суманд тариалсан 400ш улиас, 100ш бургас модыг тариалсан. Мод тус бүрийн хоорондын зай 1-1.5м орчим зайтай тариалсан бөгөөд энэ модны онцлогоос шалтгаалж зүйл хооронд ургах чадварыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг



Зураг 18 Мод тариалалтад сумын иргэд болоод албан байгууллагууд идэвхитэй оролцсон



Зураг 19 Улиас модыг тариалж буй байдал

Дэлгэр суманд мөн 500ш улиас мод тариалсан бөгөөд цооног байгаа газар тариалах нь усалгаа болоод хараа хяналт арчилгааг зэргийг шийдвэрлэхэд учир дутагдалтай тул сумын төвийн цэвэрлэжүүлэлт хийгдэж буй талбайд тариалсан.



Зураг 20 Мод тариалалтад иргэд олон нийт олноор оролцсон.



Зураг 21 Улиас модны суулгац нь 1,5-2м урттай мөн амьдрах чадвар өндөртэй байдаг.

Тэрбум модны хөтөлбөрийн хүрээнд Говь-Алтай аймагт 500ш 1.5-2м орчим өндөртэй хайлас модыг тариалсан. Хайлаас модыг Говь-алтай аймгийн мод үржүүлгийн газраас авсан бөгөөд энэ нь мөн орон нутгийг дэмжиж ажиллаж байгаа нэг хэлбэр юм.



Зураг 22 Тэрбум модны хүрээнд тариалсан хайлас мод

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Хайгуул судалгааны үед нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ авах шаардлага гараагүй.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 4 Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Археологийн дурсгал	Археологи, палентологийн зүйлс илрэх тохиолдолд түүх соёлын үнэт өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагаагаа зогсоож, авран хамгаалах арга хэмжээг авах	Өмнөх жилүүдэд хийгдсэн археологи, палентологийн судалгааны ажлаар 2023 онд хайгуул хийгдэх талбайд түүх соёлын дурсгалт газар, археологи, палентологийн олдвор тогтоогдоогүй. Ажилчдад ХАБ-ын нийт ажилчдын сургалтаар соёлын өвийг хэрхэн хамгаалах мэдээллийг өгч ажилласан. Хэрэв хайгуулын ажлын үед түүх, соёлын өв, Археологи, палентологийн зүйлс илрэх тохиолдолд түүх соёлын үнэт өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагаагаа зогсоож, авран хамгаалах шинжилгээний байгууллагаар дүгнэлт гаргуулах арга хэмжээг авч ажиллана.					Соёлын өвийг хамгаалах тухай хууль, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх
2.	Палеонтологийн дурсгал							

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Тахь Ресурс” ХХК нь Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн журамьг гаргаж, ажлын байрны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгааг ажилд гарахын өмнө өгч мөрдүүлж ажилласан байсан мөн нийт ажилчдыг ХАБЭА-н сургалтанд хамруулсан бөгөөд туслан гүйцэтгэгч компаний ХАБЭА хариуцсан мэргэжилтэнтэй хамтран ажиллаж үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байсан.

Хүснэгт 5 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Өрөмдлөгийн ажлын үед хэрэглэгдэх химийн бодисууд нь агаарт ууршин алдагдсанаар, исэлдэх урвалд орж тухайн орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй	Химийн бодисыг өрөмдлөлт ашиглах үедээ зааварчилгааны дагуу хэрэглэх, агаарт их хэмжээний хий алдахгүй байхаар зохистой хэрэглэх	Туслан гүйцэтгэх компанитай байгуулах гэрээнд тусган оруулан хяналт тавьж ажилласан бөгөөд өрөмдлөлт ашиглагдаж байгаа химийн бодисууд нь органик гаралтай полимер нэгдлүүд бөгөөд агаарт дэгдэж агаарын чанарт сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсээгүй.				Цооног өрөмдөх үед	Монгол улсын стандартууд, MNS /ISO/ 4226:2000 “Агаарын чанар MNS 4585:2016
2.	Химийн бодисыг өрөмдлөгийн машинд тээвэрлэх, хадгалах үйл ажиллагаа зохиж журмын дагуу явагдаагүйгээс химийн бодис хөрсөнд алдагдаж хөрс бохирдуулж болзошгүй	Өрөмдлөлт ашиглах химийн бодисуудыг тээвэрлэхдээ зориулалтын аргаар хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцлийн дагуу тээвэрлэх Хөрсөнд алдагдсан тохиолдолд хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх	Туслан гүйцэтгэх компанитай байгуулах гэрээнд тусганаар химийн бодисыг тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагаа болон ашиглах үед хөрсөнд асгарахаас урьдчилан сэргийлж арга хэмжээг сайтар хангаж пластик уут хөрсөн дээр дэвсэх зэрэг асгахгүй байх арга хэмжээг авч тээвэрлэлтийн хувьд холбогдох дүрэм журамыг мөрдөж ажиллахад хяналт тавин ажиллаж байсан.				Хадгалалт, тээвэрлэлтийн явцад	Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам. БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайд, ОБЕГ-ын даргын 28/40/29 дүгээр хамтарсан тушаал,

- Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд компани ажилчдад А/370 дугаар тогтоолын дагуу хээрийн ажилд гарахын өмнө нийт ажилчдын ХАБ-ийн сургалтыг орсон.
- Эрүүл мэндийн сайдын А/340-р тогтоолын дагуу нийт ажилчдыг эрүүл мэндийн даатгал, гэнэтийн ослын даатгал, эрүүл мэндийн урьдчилан үзлэгийг Ardmend даатгалтай гэрээ байгуулж ажилчдаа хамруулсан. Дээрх ажил хэрэг нь ХАБЭА-н тухай хуулийнд

заасан ажил олгогчийн нэг үүрэг юм компани ажилчдын эрүүл мэнд аюулгүй байдалд анхаарч байгаа нь нэг том соёлыг бий болгож байгаа билээ.

- Ажилчдаа ажлын тусгай болон нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангасан.
- ХАБ-н мэдээллийн самбарыг кемп болон оффист байрлуулсан бөгөөд мэдээллийн самбарт компани ХАБ-ын Зорилго, төлөвлөгөө, мэдээ мэдээлэл, хууль дүрэм журам, яаралтай үед холбоо барих утасны дугаар зэргүүдийг багтаасан байна.
- Хээрийн лабораторид гэрээтээр ажиллаж байгаа туслах ажилтануудад өдөр тутмын болон урьдчилсан ХАБ-ын зааварчилгааг өгч өдөр бүр ХАБ-ын сургалт зааварчилгааг өгч ажиллаж байсан.

Дараах ХАБ-ын дүрэм журам, зааварчилгааг мөрдлөгө болгон ажиллаж байсан.Тухайлбал:

- Жолооч нарын өдөр тутмын аюулгүй ажилгааны бүртгэл , дэвтэр
- Оффисын өдөр тутмын аюулгүй ажилгааны бүртгэл , дэвтэр
- Кемпэд ажиллах геологич нарын аюулгүй ажилгааны дэвтэр
- Даралтад сав, төхөөрөмжтэй ажиллах ААЗ (аюулгүй ажилгааны зааварч
- Өрмийн ажлын АА (аюулгүй ажилгааны) дүрэм
- Хээрийн маршрут судалгааны үед мөрдөх аюулгүй ажиллагаан зааварчи
- Эрсдэлийн үнэлгээ хийх арга аргачлал
- Хайгуулын ажлын АА дүрэм
- Замд гарах зөвшөөрлийн хуудас
- Шат тавцан ашиглах үеийн ААЗ
- Галын аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Гар багажууд ашиглах АА дүрэм зэргийг боловсруулаад байна.



Зураг 23 ХАБЭА-н мэдээллийн самбар




Зураг 24 Нийт ажилчдын ХАБЭА-н сургалт




Зураг 25 Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулж буй байдал



Зураг 26 Өрмийн талбайд ХАБ-ийн тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал



Зураг 27 Зогсоолын болон хурдаа тэмдэглэгээ тэмдэг



Зураг 28 Ажлын байрны өдөр тутамын аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч ажиллуулж байсан






Зураг 29 Ажилчдын гэрийн гадаа гал унтраагуурыг байршуулж, галын сарааг мөн байршуулсан




11. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Өрөмдлөгийн ажлыг туслан гүйцэтгэгч компани нь өрмийн ханыг бэхжүүлэх цооног хаахад зориулан дараах нэр төрөл бүхий химийн бодисын зөвшөөрлөөр олгодсон бодисыг ашигласан. Дараах бодисууд нь нэг төрлийн химийн бодис гэж нэрлэгдэх боловч органик гаралта. Тухайлбал:

Хүснэгт 6 Өрөмдлөгт ашигласан химийн бодисын нэр төрөл

Химийн бодисын нэр	Тодорхойлолт	Аюул осолын зэрэглэл	Бодисын зураг
Polxycd	<p>Polxycd нь дээд зэргийн чанартай биополемир бөгөөд энэхүү нунтаг нь өндөр хазайлттай босоо болон хэвтээ чиглэлийн өрөмдлөгийн цооногийн хатуу биетийг дээд зэргээр уусгаж цооногийн нүхийг цэвэрлэх зориулалттай. Мөн Polxycd нь шаварыг шүүж маш үр дүнтэй барьцалдуулагчийн үүргийг гүйцэтгэдэг.</p> <p>Үе давхаргын хүчин чадалын нуралтын аюулыг багасгана.</p>	Химийн аюултай бус бүтээгдэхүүн	

<p>AMC EZEE TROL</p>	<p>AMC EZEE TROL нь бүх төрлийн өрөмдлөгийн ажилд нүх тогтворжуулах шинж чанартай, шингэнийг өндөр чанартай барьцалдуулагч өндөр тархалттай олон талт полимер хольц юм. AMC EZEE TROL нь загасны нүдээрч үл харагдах шинж чанартай, үндсэн холигч төхөөрөмж байгаа хэдий ч ямар будагчтай шингэнд хурдан тархах зориулалтга</p>	<p>Химийн аюултай бус бүтээгдэхүүн</p>	
<p>AMC PLUG</p>	<p>AMC PLUG нь үйрмэг хэлбэрийн полимер бөгөөд анхны эзлэхүүнээсээ 500 дахин усыг шингээж авдаг. AMC PLUG нь эргэлтийн алдагдсан хэсгийн усыг битүүмжлэхэд тохиромжтой бөгөөд өрмийн штагны чичиргээний үеийн ус алдалтыг багасгахад ашигладаг.</p>	<p>Химийн аюултай бус бүтээгдэхүүн</p>	

<p>AMC EZEE PAC R</p>	<p>AMC EZEE PAC R нь өрөмдлөгийн шингэний системд суурилсан их хэмжээний усыг алдалтыг хянахад ашигладаг орчин үеийн өндөр чанар, өндөр тархалттай полианионик целлюлоз полимер юм. AMC EZEE PAC R нь маши нарийн ширхэгтэй бөгөөд хамгийн муу нөхцөлд ч усанд хурдан тархах зориулалттай. AMC EZEE PAC R -ийг хольсоны үр ашиг нь цооногийн өртөг болон шаварын өртөгийн алдагдалыг бууруулдаг.</p>	<p>0-Эрүүл мэндэд хор нөлөөгүй Шатахай байдлын зэрэглэл-1</p> 	
<p>AMC CR 650</p>	<p>AMC CR 650 нь өндөр молекул жинтэй, нунтаглагдсан полимер түүнчлэн тогтоцыг тогтворжуулахад тусалдаг бөгөөд таслагдсан битүүмжлэлийг AMC CR 650 нь өрөмдлөгийн хоолой, цооногийн хананд хамгаалалтын полимер хальс үүсгэдэг бөгөөд өрөмдөх үед тогтоцын хүндрэл гарахад тослогооны материалыг үүсгэж тусладаг.</p>	<p>Химийн аюултай бус бүтээгдэхүүн</p>	

12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хээрийн судалгааны ажлын үед ахуйн гаралтай хог хаягдлыг зориулалтын саванд хадгалж байгаад үйл ажиллагаа дуусах үед сум орон нутагтай байгуулсан “Хог хаягдлын гэрээ”-ний дагуу сумын төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг хаясан.

Хүснэгт 7 Хог хаягдлын төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Биелэлт	Баримтлах зүйн баримтбичиг
	1	2	3	4	5
1	Ахуйн хог хаягдал	Ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хог хаягдлын цэгрүү нийлүүлэх талаар сум орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулах, журам, нормативындагуу төлбөрийг төлөх	Өрмийн талбай кемп	Гэрээний дагуу хог хаягдлын төлбөрийг төлсөн/Баримтыг хавсаргав/	Хог хаягдлын тухай хууль
		Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах өнгөний кодчиллын дагуу сав байрлуулах /зөөвөрлөн ачиж явах боломжтойг сонгох/		Хогын саван дээр хог хаягдлын төрлийн гэмдэглэгээг наасан бөгөөд ялган ангилах дадал зуршлыг ажигчдад бий болгосон.	
2	Аюултай	Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан хадгалах, тус хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, ашиглах, устгах арга хэмжээг авна.		Тос, тослолгоо арчисан даавуу материалыг савыг тусад нь саванд төвлөрүүлж нэгдсэн төвлөрсөн хогийн цэгт нийлүүлсэн.	



Зураг 30 Түр хогийн цэгийг хашаалсан байдал



Зураг 31 Энгийн болон аюултай хог хаягдал ялгасан байдал



Зураг 32 Кемп дотор энгийн хог хаягдлын сав



Зураг 33 Кемп нүүх үед цугларсан хогийг хогийн цэгт төвлөрүүлсэн

13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

2023 онд явуулах хайгуулын ажлын төлөвлөгөөнд нарийвчилсан хайгуулын Дэлгэр талбайд Хөв булгийн нүүрсний уурхайн орчимд болон Чандань талбайд Зээгтийн нүүрсний уурхайн орчимд үртсэн болон керн хосолсон аргаар өрөмдсөн нийт 4 цооногуудийн талбайд болоод нөлөөллийн бүсэд “ Их Зос ” ХХК-аар “Байгаль орчны хяналт-шинжилгээ мониторингийн судалгааны ажил”-ыг хийж гүйцэтгүүлэв. Орчны хяналт-шинжилгээ мониторингийн судалгааны хээрийн ажлыг 2023 оны 07-р сарын 09-оос 11-ны өдрүүдэд, байгаль орчны үнэлгээний мэргэжилтэн, хөрс судлаач, ургамал судлаач болон бусад техникийн мэргэжилтнүүдээс бүрдсэн судалгааны баг хийж гүйцэтгэсэн болно. Гэрээт ажлыг Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29- ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан журмын хүрээнд 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв. Байгаль орчны хяналт-шинжилгээ мониторингийн судалгааны ажил нь тухайн төслийн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг шинжлэх ухааны үндэслэлтэй аргачлал, стандартаар хянах зорилготой байдаг. Тус судалгааны ажилд төслийн нөлөөлөлд өртсөн болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд буюу агаар, ус, ургамал, хөрсөн бүрхэвчийн орчныг хамруулав. Тухайн арга хэмжээг тогтмол буюу жил бүр хэрэгжүүлснээр төслөөс байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг эрт үед нь илрүүлэх, тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг цаг алдалгүй арилгах байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах нөхцөлийг бүрдүүлдэг.

Хүснэгт 8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Мониторинг цэг тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Хүхэрлэг хий (SO ₂), азотын давхар исэл (NO ₂), Нийт тоосонцорын хэмжилт (PM _{2.5} , PM ₁ PM ₁₀ TSP)	<ul style="list-style-type: none"> Говь-Алтай аймаг Чандмань сум TR-B4-01 цооног Дэлгэр сум-TR-B4-02-Del-TR-B4-03-Del-TR-B4-04-Del 	2023 оны 7 сард	40	36,000	288,000	Өрөмдлөгийн ажлын үед агаарын чанарт хяналт тависан	Агаарын чанар MNS 4585:2016 Дээжлэхдээ: УСТ 0017-2-5-12-1988, MNS 4048:1988, ISO 9855:1983, MNS 5002:2000
2.	Усны хүнд металлын шинжилгээ	Нарийвчилсан хайгуул болон	2023 оны 7 сард	6	98,000	294,000	Өрөмдлөгт ашиглах худаг, өрөмдлөгийн	Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй

	Усны химийн бүрэн шинжилгээ	өрөмдлөгийн талбайн ойр байх худаг	2023 оны 7 сард	16	48,000	288,000	талбай орчмын уст цэгийг тодорхойлох усны чаарын үзүүлэлтыг тодорхойлсон	байдлын үнэлгээ MNS 0900:2018
3.	Агрохимийн үзүүлэлтүүд (ялзмаг, рН, EC2.5 dS/m, P2O5, K2O, CaCO3), Механик бүрэлдэхүүн (тоос, элс, шавар)	<ul style="list-style-type: none"> • Цооног өрөмдсөн талбай • Хаягдлын сан • Ажилчдын кемп 	2023 оны 7 сард	40	28,000	560,000	Өрөмдлөгийн ажил хийх талбайн хөрсөн болон ургамлан бүрхэвчинд мониторингийн хяналтыг тавьсан	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд. MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6341:2012
	Хөрсний хүнд металл (Cr, Cd, Pb, Ni, Co, Cu гэх мэт)	<ul style="list-style-type: none"> • Цооног өрөмдсөн талбай • Хаягдлын сан • Ажилчдын кемп 	2023 оны 7 сард	40	39,000	780,000		
	Ургамлын бүлгэмэл, ургац тархац	<ul style="list-style-type: none"> • Цооног өрөмдсөн талбай • Хаягдлын сан Ажилчдын кемп 	2023 оны 7 сард					MNS5546:2005 Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага

13.1 Хөрсний мониторинг¹

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Богд-IV хайгуулын талбайд хамаарах Говь-Алтай аймгийн Чандмань, Дэлгэр сумдын нутагт хийгдсэн өрөмдлөгийн цооногуудын дагуу нийт 22 хөрсний мониторингийн судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд хөрсний механик бүрэлдэхүүн болон хүнд металлын дээжийг өрмийн цооног болон ойр нөлөөллийн бүсээс авч шинжилгээ хийсэн².

¹ Их Зос ХХК-ийн ОХШ-ний тайлан



Зураг 34 Чандмань болон Дэлгэр сумын сумын хөрсний мониторингийн цэгүүдийн байршил

Хүснэгт 9 Чандмань сумын Ch23-01 зүсэлтийн хөрсний химийн үндсэн шинж

№	Дээжний дугаар	Гүн, см	pH H ₂ O (1:5)	CaCO ₃ %	Ялзмаг %	ЕС (1:5) dS/m	Хөдөлгөөнт, мг/100г	
							P ₂ O ₅	K ₂ O
1	Хөрсний зүсэлт -1	A үе	7.96	3.27	1.941	0.178	1.57	18.6
		B үе	8.33	20.18	1.543	0.140	1.45	15.5

Хүснэгт 10 Чандмань сумын Ch23-01 зүсэлтийн хөрсний механик бүрэлдэхүүн

№	Дээжний дугаар	Гүн, см	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)		
			Элс (2-0.05 мм)	Тоос (0.05-0.002 мм)	Шавар (<0.002 мм)
1	Хөрсний зүсэлт -18	A үе	61.4	28.5	10.1
		B үе	59.9	29.3	10.8

А 0-20 см. Сайргархаг цайвар хүрэн хөрс. Уулс хоорондын тэгш тал. Алаг өвс-хялганат бүлгэмдэлтэй, гадарга 10-20 мм хүртэл ширхэглэлтэй 20-25% чулуулагтай, 2-3⁰ налуу, 10 см хүртэл чийглэг, нягтавтарт, элсэрхэг бүтэцтэй, 10 см хүртэл ургамлын үндсээр их торлогдсон. Хайгуул өрөмдлөгийн үйл ажиллагаагаар 15м х 15м хэмжээтэй талбай эвдрэлд өртсөн. Техникийн нөхөн сэргээлт хийсэн байсан.

В 20-40 см. Цайвар хүрэн хөрс. Гүндээ 5-10 мм хүртэл ширхэглэлтэй 10-20% чулуулагтай, хуурай, цэвдэггүй, нягтавтарт, элсэрхэг бүтэцтэй.



Хүснэгт 11 Чандмань сумын Ch23-01 талбайн хөрсний зүсэлт

Хөрсний мониторинг хийсэн ихэнх цэгийн үр дүнгээс харахад дийлэнх нь хөрсний элэгдэл эвдрэлд өртөөгүй. Хөрсний цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй. Хөдөлгөөнт фосфор болон хөдөлгөөнт калийн хангамжаар дунд зэрэг. Механик бүрэлдэхүүн элсэнцэр. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дундаж.

Хүснэгт 12 Дэлгэр сумын De23-01 зүсэлтийн хөрсний химийн үндсэн шинж

№	Дээжний дугаар	Гүн, см	pH H ₂ O (1:5)	CaCO ₃ %	Ялзмаг %	ЕС _(1:5) dS/m	Хөдөлгөөнт, мг/100г	
							P ₂ O ₅	K ₂ O
1	Хөрсний зүсэлт -19	A үе	8.79	1.09	4.694	0.415	2.56	26.3
2		B үе	9.11	5.09	1.098	1.098	1.21	13.4

Хүснэгт 13 Дэлгэр сумын De23-01 зүсэлтийн хөрсний механик бүрэлдэхүүн

№	Дээжний дугаар	Гүн, см	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)		
			Элс (2-0.05 мм)	Тоос (0.05-0.002 мм)	Шавар (<0.002 мм)
1	Хөрсний зүсэлт -19	A үе	68.9	17.6	13.6
2		B үе	73.3	13.9	12.8

A 0-15 см. Сайргархаг цайвар хүрэн хөрс.Тэгш тал. Алаг өвс-хялганат бүлгэмдэлтэй, гадарга 10-30 мм хүртэл ширхэглэлтэй 30-40% чулуулагтай, 2-3⁰ налуу, хуурай, нягт хөнгөн шавранцар бүтэцтэй, 20 см хүртэл ургамлын үндсээр дунд зэрэг торлогдсон. өрөмдлөгийн үйл ажиллагааны нөлөөгөөр 2м х 6м хэмжээтэй 3 хэсэг талбай эвдрэлд өртсөн. Хайгуулын өрөмдлөгийн ажил хийгдэж байсан.

В 15-40 см. Цайвар саарал. 10-30 мм хүртэл ширхэглэлтэй 20-30% чулуулагтай, хуурай, цэвдэггүй, нягт, хөнгөн шавранцар бүтэцтэй.



Зураг 35 Дэлгэр сумын De23-01 хөрсний зүсэлт



Зураг 36 De23-04 хөрсний зүсэлт

Мөн хөрсний мониторинг цэгүүдэд хөрсний хүнд металлын шинжилгээг хийсэн ба ихэнх цэгийн үр дүнгээс харахад дийлэнх нь хөрсний хүнд металлын агууламжийг “Алс ХХК”-ийн итгэмжлэгдсэн лабораторит тодорхойлуулсанаар ба MNS5850:2019 стандарттай харьцуулахад хүлцэх агууламжид байсан ба ихэнх цэгүүд хүнд металлын бохирдолгүй байсан.

13.2 Усны мониторинг ¹

Богд-IV талбайд хамаарах Говь-Алтай аймгийн Чандмань болон Дэлгэр сумын хайгуулын талбай орчмын усны мониторингийн судалгаанд 10 гадаргын болон гүний худгуудыг хамруулав. Дээжид хамрагдсан худгуудийн дийлэнх нь Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартад заасан хэмжээнээс үзүүлэлтүүд их байв. Хуурай хээрийн бүсэд хур тунадас бага ордог, температураас хамааран ууршилт их явагддаг, салхи, газрын хотгор гүдгэрийн ялгаа багатай зэрэг байгалийн хүчин зүйлсийн улмаас ихэвчлэн эрдэслэг, бичил элемент стандартаас их байх тохиолдол элбэг. Усны бохирдлын үзүүлэлтүүдийг тодорхойлохоор 3 худгийн усны дээжийн хүнд металлын агууламжийг “Алс ХХК”-ийн итгэмжлэгдсэн

лабораторит тодорхойлуулсан ба MNS6148:2010 стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнд буюу хэвийн байв.



Зураг 37 Чандмань сумын гар худаг



Зураг 38 Дэлгэр сумын Хадатын гар худаг

13.3 Агаарын мониторинг ¹

Богд-IV талбайд хамаарах Говь-Алтай аймаг Чандмань , Дэлгэр сумын НДМХ-ийн хайгуулын талбайн 2023 оны орчны хяналт шинжилгээний агаарын чанарын хэмжилтээр O_2 Хүчилтөрөгчийн хэмжээ хэвийн, CO - Шатамхай хий, H_2S - Хүхэрт устөрөгч болон CO_2 Нүүрстөрөгчийн дутуу исэл илэрсэнгүй. $PM_{1.0}$, $PM_{2.5}$, $PM_{10.0}$ тоосонцорын хэмжээ Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандартын Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн хүлцэх хэмжээнээс бага агуулгатай байна.



Зураг 39 Агаарын хэмжилт хийжэ буй байдал

Цэгийн нэр	PM 2.5 мкг/м ³	PM 1.0 мкг/м ³	PM 10 мкг/м ³	TVOC мг/м ³	AQI	Температ ур °C	Чийгшил %
Ch-01	7	4	9	0.098	Very good	29.7	23
Ch-02	8	4	10	0.000	Very good	31.9	29
Ch-03	8	4	10	0.008	Very good	38.8	93
Ch-04	6	3	8	0.002	Very good	30.7	23
Ch-05	8	4	10	0.009	Very good	22.8	31
Ch-06	7	4	9	0.007	Very good	29.6	18
Ch-07	7	4	9	0.005	Very good	30.8	17
Ch-08	9	5	11	0.005	Very good	15.2	47
Ch-09	6	3	7	0.007	Very good	14.9	53
Ch-10	8	5	10	0.007	Very good	18.9	51
Ch-12	8	3	7	0.008	Very good	23.2	29
Ch-14	11	6	13	0.176	Very good	24.4	33
Ch-15	9	5	11	0.008	Very good	22.9	32
Ch-16	8	4	10	0.005	Very good	28.4	35
Ch-17	7	4	9	0.009	Very good	26.9	29
Ch-18	8	4	10	0.009	Very good	15.2	57
Ch23-01	8	4	10	1.493	Very good	18.9	41
De23-01	6	3	7	0.325	Very good	23.7	21
De23-03	7	4	8	0.077	Very good	29.9	23
De23-04	8	4	10	0.299	Very good	30.9	23


Зураг 40 Агаарын мониторингийн цэгүүдийн PM 2.5, PM 1, PM 10 хэмжилт

Цэгийн нэр	O ₂ - Хүчилтөрөгч	EX- Шатамхай хий	H ₂ S- Хүхэрт устөрөгч	CO- Нүүрстөрөгчийн дутуу исэл
Ch-01	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
Ch-02	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
Ch-03	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
Ch-04	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
Ch-05	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
Ch-06	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
Ch-07	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
Ch-08	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
Ch-09	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
Ch-10	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
Ch-12	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
Ch-14	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
Ch-15	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
Ch-16	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
Ch-17	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
Ch-18	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
Ch23-01	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
De23-01	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
De23-03	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW
De23-04	20.9% VOL NORMAL	0 %LEL LOW	0 PPM LOW	0 PPM LOW

Зураг 41 Агаарын мониторингийн цэгүүдийн O₂ EX, H₂S, CO хэмжилт

13.4 Ургамлын мониторинг ¹

Богд-IV талбайд хамаарах Говь-Алтай аймгийн Чандмань, Дэлгэр сумын НДМХ-ийн хайгуулын талбайн 2023 оны ургамалжлын мониторинг судалгаанд нийт 12 овгийн 24 төрлийн 27 зүйл бүртгэгдсэн. Хайгуулын талбайн дээд ургац 7 дугаар сарын 1 дүгээр 10 хоногийн байдлаар бүлгэмдлүүдийн дунджаар 2.7 ± 2.2 ц/га байсан. Бид төслийн талбайг төлөөлүүлэн 21 цэгийг сонгон ургамалжлын судалгааг гүйцэтгэсэн бөгөөд 1 м²-д дунджаар 4 зүйл ургамалтай, тохиолдох зүйлийн баялгаар хамгийн их Ch-17 талбай, хамгийн бага зүйлийн баялагтай Ch-04 талбай байв. Ch-03 талбай зүйлийн олон янз байдал хамгийн их, бүлгэмдэл дэх зүйлүүд жигд өндөр оролцоотой. D23-03 талбайд Үндсэрхэг сонгино зонхилсон. Судалгааны бусад талбайд зүйлийн олон янз байдал, жигд байдал, зонхилогчийн индекс төсөөтэй буюу талбай хооронд ялгаа багатай.




Зураг 42 Ургамлын мониторингийн хяналтын цэгүүдийн байршил



Зураг 43 Дэлгэр сумын De23-01 ургамлын мониторингийн цэг

Зураг 44 Чандмань сумын Ch-04 ургамлын мониторингийн цэг



Зураг 45 Ургамлын мониторингийн цэгүүдийн индекс

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Тахь Ресурс” ХХК нь удирдлагуудын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2023 БОМТөлөвлөгөөг БОАЖЯ-аар батлуулж төлөвлөгөөнд заагдсан ажлуудыг гүйцэтгэсэн. БОМТөлөвлөгөөний биелэлтийн хэрэгжилтэд туслан гүйцэтгэгч компанитай хамтран ажилласан. Хайгуулын үйл ажиллагааны үед байгаль орчин ХАБ-тай холбоотой арга хэмжээг авч , холбогдох зөвшөөрөл гэрээ аймаг сум орон нутагтай хамтран байгуулж ажилласан. Тухайлбал :

- 2023 оны ашиглалтын хайгуулын ажлын төсөв, төлөвлөгөөг батлуулж мөрдөж ажилласан.
- Орчны хяналт шинжилгээг “ИХ ЗОС” ХХК-тай хамтын гэрээ байгуулж зөвлөгөөний дагуу ажлуудыг хэрэгжүүлсэн.
- Говь-Алтай аймгийн БОАЖГазраар ус ашиглах дүгнэлтийг гаргуулж , сум орон нутагтай ус ашиглах гэрээг байгуулж усыг зөв зохистой гэрээний ашиглаж төлбөрийг барагдуулсан.
- Кемп түр байрлах зориулалтаар ашиглах газрын зөвшөөрлийг сумын Засаг даргаас авж газар ашиглах гэрээг байгуулж гэрээний дагуу үйл ажиллагааг явуулж төлбөрийг барагдуулсан.
- Хог хаягдлын гэрээг сум орон нутагтай байгуулж, хог хаягдлыг зориулалтын хогын цэгт нийлүүлж төлбөрийг бүрэн төлж гэрээний үүрэгээ биелүүлэн ажилласан.
- ХАБЭА-н чиглэлээр хээрийн ажилд явахын өмнө нийт ажилчдад А/370-р тогтоолын ХАБЭА-н сургалтын хөтөлбөрийн хүрээнд дагуу ХАБЭА-н хуулийн зорилго, зорилт, хамрах хүрээний ойлголт, галын аюулгүй байдлын сургалт, цахилгааны аюулгүй байдал, мэргэжилээс шалтгаалах өвчин, үйлдэрлэлийн осол, хурц хордого, аюулгүй ажиллагааны зааварчилгаа , осолдох дөхсөн тохиолдол, осолд өртөгсдөд үзүүлэх анхны тусламж, ажилчдыг А/340 дугаар тогтоолын дагуу эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулсан гэх мэт агуулга бүхий ХАБЭА-н сургалтыг орж өдөр тутамын ажлын байрны зааварчилгааг өгч хяналт тавин ажилласан.

15. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	Аймаг, сумын байгаль орчны газар	Мэдээлэл хүргүүлэх	Агаар, ус, хөрсний шинжилгээний дүн	Судалгааны ажил эхлэхээс өмнө тухайн ажил явагдах сумдын байгаль орчны улсын байцаагч, засаг дарга, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажилласан. Мөн нөлөөллийн бүсийн буюу судалгааны ажил явагдах талбайд байрлах айл өрхүүдэд урьдчилан мэдэгдсэн. Хайгуулын ажил хийгдэж дууссаны дараа сумын байгаль орчны байцаагчид хүлээлгэн өгсөн.		“Тахь ресурс” ХХК	Сумын ЗДТГ
2.	Багийн ИНХ	Тайлагнах, мэдээлэл хүргүүлэх	Агаар, ус, хөрсний шинжилгээний дүн			“Тахь ресурс” ХХК	Багийн хурлын танхим
3.	Аймгийн БОАЖГ	Танилцуулах	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлт гаргуулах			“Тахь ресурс” ХХК	БОАЖГ
4.	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т албан бичиг	Төлөвлөгөөг хэвлэмэл хэлбэрээр	БОМТ			“Тахь ресурс” ХХК	УБ хот, БОАЖЯ
	Нийт	-	-	-	-	-	-

Хайгуулын ажил эхлэхийн өмнө болоод дараа нь нөлөөллийн бүсийн иргэд айл өрхөд 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөн сөрөг нөлөөллийг бууруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, нөхөн сэргээлтийг хийсэн үйл явц, дүйцүүлэн нөхөн сэргээлт, тэрбум модны хөтөлбөрийн хүрээнд тарьсан мод, хог хаягдлын гэрээ, ус ашиглалтын гэрээ, газар ашиглалтын гэрээний үүргээ биелүүлсэн байдал, гэрээний дагуу зохих төлбөр төлсөн байдал НДМХ-ийн үйл ажиллагаа ач холбогдол компани хайгуулын ажлын үйл явцын талаар мэдээлэл өгсөн.



Зураг 46 Дэлгэр сумын удирдлагуудад хайгуулын үйл ажиллагаа, БОМТөлөвлөгөөний талаар мэдээлэл өгж буй байдал



Зураг 47 Чандмань сумын удирдлагуудад хайгуулын үйл ажиллагаа БОМТөлөвлөгөөний талаар мэдээлэл өгж буй байдал



Зураг 48 Дэлгэр сумын нөлөөллийн бүсийн айл өрх, иргэдэд мэдээлэл өгч буй байдал



Зураг 49 Чандмань сумын нөлөөллийн бүсийн айл өрх, иргэдэд мэдээлэл өгч буй байдал

16. ДҮГНЭЛТ

Манай компани нь шинэ эрчим хүчний эх үүсвэр НДМХ хайгул судалгааны ажлыг шат дараалалтай явуулж, эдийн засгийн хувьд ач холбогдолтой хэтийн төлөв бүхий метан хийн нөөцийг олж илрүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Монгол Улсын баруун хэсэгт орших НДМХ-ийн Богд-IV блокын талбай нь Говь-Алтай аймгийн Чандмань, Дэлгэр сумын газар нутгийг хамрах нарийвчилсан хайгуулын талбайг өмнөх хайгуул судалгааны үр дүнд үндэслэн ялгасан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 дугаар бүхий тушаалаар баталсан шинэчилсэн журмын дагуу “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах хяналт тавих журам-д заасны дагуу 2023оны менежментийн төлөвлөгөө боловсруулж , төлөвлөгөөнд заагдсан ажлыг хэрэгжүүлэн ажиллаа. Үүнд:

2023 менежментийн төлөвлөгөөний биелэлт :

1. Сөрөг нөлөөлөлийг буурлахаар төлөвлөсөн ажлуудыг гүйцэтгэсэн
2. Цооногуудын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийсэн
3. Дүйцүүлэн нөхөн сэргээлт болон тэрбум модны хүрээнд Хайрхандулаан суманд 4200ш болон Нарийнтээл ширхэг модыг тарилаа.
4. “Их Зоос” ХХК-тай хамтарсан гэрээг байгуулж 7-р сард Орчны Хяналт шинжилгэний хөтөлбөрийн хэрэгжүүлсэн
5. Чандмань болон Дэлгэр сумын Засаг даргын захирамжаар газрын даамалтай газар ашиглах гэрээг байгуулсан.
6. Говь-Алтай аймгийн БОАЖГазраар усны нөөц ашиглалтын мэргэжилтэнээр Ус ашиглах дүгнэлтийг гаргуулж, сум орон нутагтай Ус ашиглах гэрээг байгуулж төлбөрийг барагдуулж ажилласан.
7. Байгаль орчин , Хөдөлмөрийн аюулгүй байдал, Галын аюулгүй байдал , Хог хаягдлын менежемент , Мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрийн осол хурц хордлого А/370 тогтоолын дагуу хөтөлбөрийг гаргаж нийт ажилчдын нэгдсэн сургалтыг оруулсан.
8. Нийт ажилчидда А/340-р тогтоолын дагуу Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийг хувийн хэвшлийн эмнэлэгийн байгууллагатай хамтран хийсэн гэх зэрэг 2023 оны БОМТ төлөвлөгөөнд тусгагдсан ажилуудыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

Хавсралт

МОНГОЛ УЛС
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

23 06 14 878
20 .. оны ... сарын ... өдөр Дугаар Улаанбаатар хот

Эрхлэх үйл ажиллагааны төрөл

Уламжлалт бус газрын тосны хайгуулын "Богд IV", "Онги V", "Т1" талбайд /нүүрсний давхаргын метан хий/ хайх

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр

"Тахь ресурс" ХХК /хуучин нэрээр Петровис ресурс ХХК/

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо

Регистрийн дугаар

5513618

Тусгай зөвшөөрлийн хугацаа

2031 оны 06 сарын 05 хүртэл

Тусгай нөхцөл, шаардлага

Холбогдох хууль, дүрэм журмын шаардлагыг хангаж ажиллах.

Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 202.3 оны .. 06 сарын
.. 14- өдрийн А/232 дугаар тушаалыг үндэслэн олгов.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД



Ж.ГАНБААТАР

СУНГАЛТ:

Тусгай нөхцөл шаардлага:

СУНГАЛТ:

Тусгай нөхцөл шаардлага:



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000263258

2011.09.16 / Бүртгэсэн он, сар, өдөр /
9019097258 / Хувийн хэргийн дугаар /
5513618 / Регистрийн дугаар /

Тахь ресурс / Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /
Гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани

Дүрэм / Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр / шийдвэрийн нэр / 1 / дугаар / 2011.09.09 / он, сар, өдөр /

4610 Гадаад худалдаа / Код /
09901 Уламжлалт бус газрын тос /нүүрсний давхаргын метан хий/ хайх /2021.06.18-2030.03.05/ / Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй / хугацаа / 1 / гишүүдийн тоо / 8,409,382.50 / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, жамьян гүний, Хөх тэнгэр цамхаг 502 тоот, Утас1: 70116125, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хвьяг /




ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР

Бүртгэсэн байгууллагын нэр /
УЛСЫН БҮРТГЭГЧ / Э.МӨНХЗАЯА / гарын үсэг /
/ гэмдэг /

Гэрчилгээ дахин олгосон 2022 он 12 сар 12 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Давааням овогтой Энхмаа-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2014.09.26	
2	Дахин гэрчилгээ олгов.	2022.12.12	



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000263258


 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН ДӨРГӨДӨХ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
 ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**
 Говь-Алтай аймгаар, Есөнбузар сум, Жаргалант баг, 82083
 Цэвэр шуудан.govi/altai.baigalionchir@gmail.com
 Цахим хуудас: gov-i-altai.nature.gov.mn
 Утас/Факс: 70-48-49-54

2023. 05. 30 № 192
 танил _____ -ийн № _____

"ТАХЬ РЕСУРС" ХХК-Д

Шиглүүг тах дүгнэлт хүргүүлэх тухай

Монгол улсын "Усны тухай" хуулийн 4 дүгээр бүлгийн 28 дугаар зүйлийн 28.4 дүгээр заалт, Говь-Алтай аймгийн Дэлгэр, Чандмань сумын нутагт Уламжлалт бус усны тос хайх Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны А/168 дугаар тусгай зөвшөөрөл эзэмшигч "Тахь Ресурс" ХХК-д 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тусгай зөвшөөрлийн ажлын төлөвлөгөө, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгалийн бодлогын бодлого зохицуулалтын газрын 06/2904 дугаар лавлагаа зэргийг үндэслэн Дэлгэр, Чандмань сумын нутагт эрэл хайгуулын өрөмдлөг хийх зориулалтаар ус шиглүүлэх дүгнэлтийг гарган хүргүүлэв.

Хавсралт хуудастай.

Хувиар Дэлгэр, Чандмань сумын Засаг даргад Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 23.1.1-д заасны дагуу зөвшөөрөл олгож, гэрээ байгуулан хамтран ажиллана

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
 ГҮЙЦЭТГЭГЧ  Г.БОЛДБААТАР


My blank Toop-A4

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ**

2023 оны 05 дугаар
сарын 30-ний өдөр

Дугаар *192*

Алтай хот
утас, факс: 70484954

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар. "Тахь Ресурс" ХХК, Гүйцэтгэх захирал Д.Энхмаа, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 51, Амрын гудамж 7, Петровис байр, утас:312483, 99927981, 89966311, Улсын бүртгэлийн дугаар 9019097258, регистрийн дугаар 5513618

2. Төслийн нэр, байршил. Говь-Алтай аймгийн Бигэр, Дэлгэр, Есөнбулаг, Тайшир, Халиун, Чандмань, Эрдэнэ сумын нутагт орших "Богд IV" нэртэй талбай нь Дэлгэр сумын талбайн Алтай хотоос 105, Чандмань сумын талбай 258 километрийн зайд, Хяргас нуур-Завхан голын сав газарт хамрагдана.

3. Төсөл хэрэгжүүлэгч. "Тахь Ресурс" ХХК

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат (X, Y). Уламжлалт бус газрын тос хайх тусгай зөвшөөрлийг Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А/168 дугаар тушаалаар олгосон байна. №-679: (Чандмань сумд 340380.3 га талбай)

№	Уртраг			Өргөрөг			№	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек		град	мин	сек	град	мин	сек
1	97	51	0.00	45	26	0.000	6	98	0	0.001	45	23	41.029
2	97	54	47.165	45	26	0.086	7	98	0	0.000	45	20	0.000
3	97	54	47.165	45	24	23.400	8	97	55	14.525	45	20	0.088
4	97	56	29.045	45	24	23.400	9	97	55	14.525	45	21	23.040
5	97	56	29.045	45	23	40.92	10	97	51	0.001	45	21	23.099

(Дэлгэр сумд 356249.52 га талбай)

№	Уртраг			Өргөрөг			№	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек		град	мин	сек	град	мин	сек
1	97	21	47.3	46	21	51.8	4	97	29	33.9	46	00	32.6
2	97	27	51.14	46	21	36.7	5	97	12	27.0	46	00	32.6
3	97	27	51.4	46	17	49.9	6	97	12	27.0	46	04	21.5

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт. Уламжлалт бус газрын тос хайх эрэл хайгуулын өрөмдлөгийн ажил

6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал. БНСАУ үйлдвэрлэсэн YOUNGJIN YJ-900 DRILLING RIG маркийн өрмийн машин ашиглах бөгөөд NQ NQ /76мм/-1600м, HQ HQ /89мм/-1200м, PQ PQ /114мм/-600м, хөдөлгүүр D12, DI1100g00103789, хэмжээ урт 9.5м, өндөр 2.5м-9.8м, усны худаг 8" (200м) хүчин чадалтай өрөмдлөгийн машин хоногт 2 ээлж 24 цагаар, 6 сар буюу 150 хоног ажиллана.

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ. 2023 онд Дэлгэр 600т/м 1 цооног, Чандмань сумд 800 т/м 2 цооног, 400-600м гүнтэй 3 цооног буюу 1400/м өрөмдлөгийн ажил хийгдэнэ.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ. Усны эх үүсвэр нь

газрын доорх болон дээрх уснаас ашиглах ус бөгөөд Дэлгэр сумын төвийн ундны 2 худгаас, Чандмань сумын гутагт орших Ботгон голын Хиймэл нуураас зөөврөөр хангана.

Саадны худгийн шинжилгээний дүнгээс харахад ус нь сул шүлтлэг орчинтой, гидрокарбонат - кальци, натрийн төрлийн цэнгэг усны ангилалд хамаарагдаж байна. Мөн тус худгийн ус нь химийн найрлага, бичил элемент, бичил амь судлал, цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ "Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ" MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангаж байна.

Ойн зурвасын худгийн шинжилгээний дүнгээс харахад ус нь сул шүлтлэг орчинтой, гидрокарбонат - кальци, магнийн төрлийн цэнгэг усны ангилалд хамаарагдаж байна. Мөн тус худгийн ус нь химийн найрлага, бичил элемент, бичил амь судлал, цацрагийн аюулгүйн үзүүлэлтээрээ "Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ" MNS 0900:2018 стандарт шаардлагыг хангаж байна. Унд-ахуйд хоногт 3м^3 , үйлдвэрлэлийн хэрэгцээнд 46.6м^3 , хоногт нийт 49.6м^3 ус хэрэглэнэ.

9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, хэмжээ хийц, дамжуулах шугам сүлжээний урт, диаметр/. Дэлгэр сумын Саадны худгийн гүн 110м, Ойн зурвасын зориулалтын худгийн гүн 90м бусад мэдээлэл байхгүй, Ус дамжуулах шугам сүлжээгүй бөгөөд усаа 5 тонн ус агуулах савтай URAL-375 маркийн автомашинаар зөөвөрлөж ашиглана.

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/- Худгуудыг ЭЦВ-10-110 насосоор тоногосон. $10\text{м}^3/\text{цаг}$ подачтай, 110м өргөх чадалтай, тоолуургүй, барилга байгууламжтай.

Саадны худаг 1- $46^\circ 21' 5.8''$, $97^\circ 21' 40.6''$

Ойн зурвасын худаг 2- $46^\circ 21' 14.8''$, $97^\circ 22' 16.6''$

11. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2021 онд "Питровисресурс" ХХК хийсэн байна.

12. Онцгой нөхцөл. Хайгуулын өрөмдлөгт хэрэглэгдэх усыг эргэлтийн сан ашиглан ашигласан усыг дахин хэрэглэх нөхцөлийг хангах.

13. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дугаар тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-ын 12 дугаар хавсралтын 2-д заасны дагуу тооцоход:

$150\text{ л/хон} \times 20\text{ хүн} \times 150\text{ хоног} = 450\text{м}^3/\text{жил}$ - Ажилчдын унд ахуйд хэрэглэх усны хэмжээ:

Ажилчдын тоо-20 хүн ("Таях Ресурс" ХХК 2023 оны 0104/23 дугаар албан бичиг үндэслэв)

1 хүн хоногт хэрэглэх усны хэмжээ-150л/хон (Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дугаар тушаал)

Ажиллах нийт хоног-150хоног ("Таях Ресурс" ХХК 2023 оны 23/14 дугаар албан бичиг үндэслэв)

Эрэл хайгуулын өрөмдлөгт ашиглах усны хэмжээ:

Шууд угаалгатай өрөмдлөг, 89мм голчтой

$1400\text{т/м жил} \times 10\text{м}^3 : 100\text{т/м} = 140\text{м}^3/\text{жил}$ - Эрэл хайгуулын өрөмдлөгт шаардагдах ус (А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтын 2.1)

Усаар цооног цэвэрлэх.

400 т/м түүнээс дээш бол 440м^3 усыг нэг цооног цэвэрлэхэд зарцуулна. Дундаж гүн $400\text{--}600\text{ т/м}$ (Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд

зарцуулах усны норм батлах тухай Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтын 2.3 тооцвол)

Чандмань сумд 2 цооног х 440 = 880 м³/жил

Дэлгэр сумд 1 цооног х 440 = 440 м³/жил

Нийт 880+440= 1320 м³/жил -Цооног цэвэрлэхэд шаардагдах ус

Цооногийн бэхэлгээнд.

Цооногийн бэхэлгээний яндангийн голч 76мм (2015 оны А/301 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 2.4 тооцов)

1400 х 0.14 : 10м= 19.6м³/жил - Цооногийн бэхэлгээнд шаардагдах ус

140м³+1320м³+19.6м³ =1479.6м³/жил-Эрэл хайгуулын өрөмдлөгт шаардлагатай нийт ус

Зам талбайн тоосжилт бууруулахад ашиглах усны хэмжээ:

Дэлгэр 30 хон х 76000 м² х 1х 2л/м²=4560м³/жил

Чандмань 30 хон х 16000м² х 1х 2л/м²=960м³/жил

Услах хоног-30 (2023 оны хайгуулын ажиллагааны төлөвлөгөөг үндэслэв)

Услагдах талбай – 76000м², 16000 м² (2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэв)

2 хоногт услах хэмжээ – 1 удаа (2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэв)

1м² газрын тоосжилт дарахад ашиглагдах хэмжээ – 2л (2015 оны А/301 дугаар тушаалын 13 дугаар хавсралтын 7)

4560м³/жил+960м³/жил = 5520м³/жил - Тоосжилт бууруулахад шаардагдах ус

Жилд ашиглах нийт усны хэмжээ:450м³+1479.6м³+5520 =7449.6 м³/жил

14. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийг урьдчилсан байдлаар тооцоход. Унд ахуйн зориулалтаар ашиглах 450м³ газрын доорх усны төлбөрийг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 87 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Хяргас нуур-Завхан голын сав газарт тогтоосон экологи эдийн засгийн суурь үнэлгээ, Засгийн газрын 2013 оны 327 тоот тогтоолыг үндэслэн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 заалт, Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай Засгийн газрын 326 дугаар тогтоолд заасан хувь хэмжээг ашиглан урьдчилсан байдлаар тооцвол:

1м³ усны нөөц ашигласны төлбөр: 2716 төг/м³ х 0.3 х 0.15 = 122.22төг/м³

2716төг/м³ – Хяргас нуур-Завхан голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэ,

0.3 – Хүн амын унд ахуйн зориулалтаар газрын доорх ус ашиглалтыг тооцох итгэлцүүр,

15% – Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 10-д заасан хувь, хэмжээ

Унд ахуйн усны төлбөр: 450м³ х 122.22 төг/м³ = 54,999

/Тавин дөрвөн мянга есөн зуун ерөн есөн төгрөг /

"Төсвийн тухай" хуулийн 23.8 дахь заалтын дагуу Говь-Алтай аймгийн Дэлгэр, Чандмань сумын төсөвт төвлөрүүлэх.

Эрэл хайгуул өрөмдлөгт ашиглах 1479,6м³ усны 519 м³ газрын доорх, 959.6 м³ гадаргын ус, зам талбайн тоосжилт бууруулахад ашиглах 5520м³ усны 4560м³ газрын доорх, 960 м³ гадаргын усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Хяргас нуур-Завхан голын сав газарт тогтоосон экологи эдийн засгийн суурь үнэлгээ, Засгийн газрын 2013 оны 326, 327 тоот тогтоолуудад заасан хувь хэмжээг ашиглан урьдчилсан байдлаар тооцвол:

1м³ Газрын доорх усны нөөц ашигласны төлбөр : 2716төг/м³ х 1.7 х 0.2 =

923,44 төг/м³

2716төг/м³ – Хяргас нуур-Завхан голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэ,

1.7 – Эрэл хайгуулын өрөмдлөгийн зориулалтаар газрын доорх ус ашиглалтыг тооцох итгэлцүүр,

20% – Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 7г-д заасан хувь, хэмжээ

Усны төлбөр: 519м³/жил х 923.44төг/м³ = 479,256.36

1м³ Гадаргын ус ашигласны төлбөр: 1675төг/м³ х 1 х 0.1 = 167.5төг/м³

1675төг/м³– Хяргас нуур-Завхан голын сав газарт тогтоосон газрын гадаргын усны экологи, эдийн засгийн суурь үнэ,

1– Эрэл хайгуулын өрөмдлөгт гадаргын ус ашигласныг тооцох итгэлцүүр,

10%–Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 7г-д заасан хувь, хэмжээ

төлбөр: 959.6м³/жил х 167.5төг/м³ = 160,733

Эрэл хайгуулын өрөмдлөгт ашигласан усны төлбөр нийт:

479,256.36+160,733=639,989.36

/Зургаан зуун гучин есөн мянга есөн зуун наян есөн мянган гучин зургаан мөнгө/

Зам талбайн тоосжилтод 1м³ газрын доорх ус ашигласны төлбөр:

2716 х 0.3 х 20% = 162.96 төг/м³

1675 төг/м³–Хяргас нуур-Завхан голын сав газрын газрын доорх усны экологи эдийн засгийн суурь үнэлгээ

0.5 – Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын авто зам засварт ашигласан газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

10% - Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 4-т заасан хувь, хэмжээ

төлбөр: 4560м³/жил х 162.96төг/м³ = 743,097.6төг

Зам талбайн тоосжилтод 1м³ гадаргын ус ашигласны төлбөр:

1675 х 0.5 х 0.1 = 83.75 төг/м³

1675төг/м³ - Хяргас нуур-Завхан голын сав газрын гадаргын усны экологи эдийн засгийн суурь үнэлгээ

0.5 – Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын авто зам засварт ашигласан усны зориулалт тооцох итгэлцүүр

10% - Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 4-т заасан хувь, хэмжээ

төлбөр: 960 м³/жил х 83.75төг/м³ = 80,400төг

Зам тайлбайн тоосжилтийн зориулалтаар ашигласан усны төлбөр нийт:

743,097.6+80,400= 823,497.6

/Найман зуун хорин гурван мянга дөрвөн зуун ерөн долоон мянган зургаан мөнгө/

Үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны нийт төлбөр :

639,989.36 + 823,497.6 = 1,463,486.96

/Нэг сая дөрвөн зуун жаран гурван мянга дөрвөн зуун жаран найман мянга ерөн зургаан мөнгө/-ийг "Төсвийн тухай" хуулийн 23.6.5 дахь заалтын дагуу Говь-Алтай аймгийн Төрийн сан банкны усны төлбөрийн 100050000944 тоот дансанд энэ оны 06 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлнэ үү.

15. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар - Нормын дагуу шаардагдах усыг газрын доорх уснаас авч хайгуулын өрөмдлөг, ажиллагсдын ахуйн хэрэгцээнд ашиглан хөрсөнд нэвчүүлэн устгах.

16. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмж

- Ус ашиглах дүгнэлтийг үндэслэн "Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Дэлгэр, Чандмань сумын Засаг даргаас ус ашиглах зөвшөөрөл авах.
- Мөн хуулийн 28.11-д заасны дагуу Дэлгэр, Чандмань сумын Засаг даргатай гэрээ байгуулж, ус ашиглах эрхийн бичиг авснаар танай байгууллагын ус ашиглах эрх үүсэх болно.
- Мөн хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах.
- Мөн хуулийн 31.2-т зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар өсгөн тооцож төлөхөөр заасныг анхаарч, жил бүрийн ажлын төлөвлөгөө, календарьчилсан графикайг үндэслэлтэй, үнэн зөв гарган ирүүлж байх.
- Худаг усны тоолуур суурилуулж мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан тоолуурын заалтыг сумын татварын болон байгаль орчны хяналтын албадаар тогтмол хянуулж, усны төлбөрийг тоолуурын заалтаар улирал бүр тооцуулан төлж барагдуулж байх.
- Мөн хуулийн 24.1-д заасан Усны сан бүхий газарт цацраг идэвхт болон химийн хорт бодис, халдвар үүсгэгч, хог хаягдал, бохир ус хаях, машин техник, бохир зүйл угаахыг хориглоно гэсэн шаардлагыг ханган ажиллах.
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал, жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалын хавсралт "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэм"-ийг мөрдөн ажиллаж, хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байх.
- Мөн хуулийн 30 дугаар зүйлд заасан ус ашиглагчид тавигдах шаардлага болон ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний хэрэглээнээс гарсан хаягдал усыг хүрээлэн байгаа орчинд нийлүүлэхэд "Хаягдал ус. Ерөнхий шаардлага" MNS4943:2015 стандартыг мөрдөн ажиллах.
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/82/128 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам"-ыг хэрэгжүүлж ажиллах.
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо хэмжээг 2023 оны 12 дугаар сарын 20-ны дотор багтаан БОАЖГ-т ирүүлэх.

ХЯНАСАН:

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.БАТМАГНАЙ

БОЛОВСРУУЛСАН:

ХБОБН-ИЙН ХЭЛТСИЙН УСНЫ НӨӨЦ АШИГЛАЛТ,
ХАМГААЛАЛТ, ТӨРИЙН БҮС БАЙГУУЛАГА ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.СОДМАА

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2023 оны 05 сарын 31 өдөр

№ 01

Чандмань сум

Усны тухай хуулийн 29 дүгээр зүйл, Говь-Алтай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн 192 тоот ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн Ус ашиглуулагчийг Байгаль орчин аялал жуулчлалын газар Чандмань сумын Байгаль хамгаалагч Б.Адъяатөмөр Ус ашиглагчийг төлөөлж 9019097258 улсын бүртгэлийн дугаар, 5513618 регистрийн дугаартай "Тахь ресурс" ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Энхмаа нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг байгуулав.

Гэрээний нөхцөл:

1. Ус ашиглах зориулалт:

Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын цооног өрөмдөх / Стратиграфийн цооног/

2. Ашиглах усны хэмжээ:

- a) Ахуйн зориулалтаар: 20 хүн х 150л/хон х 90 хоног=270 м³жил
- b) Үйлдвэрлэлийн зориулалтаар: 800т/м жил х10м³/хон : 100=80м³/жил - Хайгуулын өрөмдлөгт шаардагдах ус / А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтын 2.1/
- c) Усаар цооног цэвэрлэх .
400 т/м түүнээс дээш бол 440 м³ усыг нэг цооног цэвэрлэхэд зарцуулна. Дундаж гүн 400-600т/м / Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулагдах усны норм батлах тухай Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтын 2,3 тооцвол /
Чандмань сумд : 2 цооног х 440 = 880 м³/жил -цооног цэвэрлэхэд шаардагдах ус.
- d) Цооног бэхэлгээнд :
Цооног бэхэлгээнд яндангийн голч 76мм / 2015 оны А/301 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 2,4 тооцов /
800 т/м х 0,14 :10 м = 11.2м³/жил - Цооногийн бэхэлгээнд шаардагдах ус 80м³/ + 880м³ + 11.2м³ = 971.2м³/жил - Нийт хайгуулын өрөмдлөгт шаардлагатай ус.
- e) Зам талбайн тоосжилт бууруулахад ашиглах усны хэмжээ :

Чандмань 30 хон $16000 \text{ м}^3 \times 1 \times 2 \text{ л/м}^2 = 960 \text{ м}^3/\text{жил}$ -Тоосжилт

бууруулахад шаардагдах ус

Услах хоног- 30 хоног /2023 оны хайгуулын ажиллагааны
төлөвлөгөөг үндэслэв /

Услагдах талбай – 16000 м² / 2023 оны хайгуулын ажиллагааны
төлөвлөгөөг үндэслэв /

1м² газрын тоосжилт дарахад ашиглагдах хэмжээ – 2 л / 2015
оны А/301 дугаар тушаалын 13 дугаар хавсралтын 7/

Жилд ашиглагдах нийт усны хэмжээ : $270 \text{ м}^3 + 971.2 \text{ м}^3 + 960 \text{ м}^3 = 2201.2$

м³/ жил

3. Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн Ус ашиглуулах 192 дугаар дүгнэлт, Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийг урьдчилсан байдалаар тооцоход:

